

## ЖАРГАЛАНТ СУМЫН 12 ДУГААР ЦЭЦЭРЛЭГТ ХИЙСЭН ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА

### Нэг. Шалгалтын зорилго

Ховд аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны даргын баталсан 35/01/11 тоот удирдамжийн дагуу Жаргалант сумын 12 дугаар цэцэрлэгийн 2018, 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд төрийн өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалтын байдал, төсөв санхүү, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэнд үнэлгээ дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, эрсдэлээс урьдчилан сэргийлж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан ажиллахад оршино.

### Хоёр. Шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

Санхүүгийн хяналт аудитын албанаас 2020 оны 10 дугаар сарын 06-наас 10 дугаар сарын 16-ны хооронд шалгалт хийлээ.

### Гурав. Шалгалтанд хамрагдсан асуудал

Тус байгууллагын 2018, 2019 оны санхүүгийн үйл ажиллагааг анхан шатны болон нягтлан бодох бүртгэлд үндэслэн Монгол улсын санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн болон бусад хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар журмын хэрэгжилтийг нягтлан бодох бүртгэл, анхан шатны баримт материал, тайлан тэнцэлд тулгуурлан явуулав.

### Дөрөв. Шалгалтанд хамрагдсан объектын талаарх товч мэдээлэл

Жаргалант сумын 12 дугаар цэцэрлэг нь Хүүхдийн танин мэдэх хүсэл эрмэлзэлд тулгуурлан эрүүл бие, үнэнч ариун, эерэг чанар төлөвшилтийн үндсийг бүрдүүлж хамтдаа байх, бусдаасаа суралцах, тоглож, хийж турших аливаа зүйлийн учрыг олох зэргээр хүүхэд бүр өөрийн онцлог, бүтээлч үйлээрээ дамжуулан хөгжихөд багш, эцэг эх хамтран дэмжлэг үзүүлэх зорилго дэвшүүлэн ажиллаж байна. Тус цэцэрлэг нь Сургуулийн өмнөх боловсролын сургалтын

хөтөлбөрийг шинэчлэх, хүүхдийн хөгжлийн ахицыг бодитой үнэлэн ахиц гаргах, Багш ажилчдын ёс зүйг чанд мөрдөн ажиллах, багш нарыг ажлын байран дээр хөгжүүлэх боломжоор хангах, арга зүйг сайжруулах, шинэ технологи туршлагыг бусдад түгээн дэлгэрүүлэх, хүүхдийг эх хэлээрээ зөв ярих чадварыг сайжруулан Номын гэгээ, Авьяас хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн авьяасыг нээн хөгжүүлэх, үзэл баримтлал, орчны стандартын дагуу тав тухтай осол аюулгүй эрүүл орчинг бүрдүүлэн, хоолны илчлэг нормыг сайжруулан, хоолны нэр төрлийг олшруулах, төсвийг ил тод нээлттэй байлгаж, олон нийтийн оролцоотойгоор хөрөнгө оруулалтыг сайжруулах зэрэг зорилтуудыг тавьж ажиллажээ.

Тус цэцэрлэг нь Монгол улсын Боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай, Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Хөдөлмөрийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Шилэн дансны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Монгол улсын бусад хууль эрх зүйн актуудыг удирдлага болгон ажил үйлчилгээний чанар, бүтээмжийг дээшлүүлэн улсын төсвийн санхүүжилтээр байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулж иржээ.

Тус цэцэрлэг нь 2018, 2019 онуудад 7 бүлэгтэй, 25 орон тоотой, 175 хүүхэдтэйгээр үйл ажиллагаагаа явуулж иржээ.

Шалгагдах хугацааны Төрийн сангийн 100161715212, нэмэлт санхүүжилтийн 100161715419 тоот дансны хөрөнгийн эрх захирагчийн нэгдүгээр гарын үсгийг эрхлэгч А, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч О нар зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулж, гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллаж ирсэн байна.

#### Тав. Төсвийн бүрдүүлэлт зарлага, санхүүжилтийн талаар

2018 онд тус цэцэрлэг нь улсын төсвийн санхүүжилтээр 351296.7 мянган төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр улсын төсвөөс 352509.6 мянган төгрөг зарцуулж, 1212.8 мянган төгрөгөөр хэтрүүлж ажиллажээ.

2018 онд нийт зардлын 54.4%-ийг цалин хөлсөнд, 6.5%-ийг НДШ-д, 13.7%-ийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд, 14.3%-ийг хоолны зардалд, 7.6%-ийг хөдөө орон нутагт ажилласны тэтгэмжинд, 1.3%-ийг хангамж бараа материалын зардалд, 2.2%-ийг бусад зардалд зарцуулжээ.

2019 онд тус цэцэрлэг нь улсын төсвийн санхүүжилтээр 375029.6 мянган төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр улсын төсвөөс 375029.6 мянган төгрөг зарцуулж, батлагдсан төсвийн хүрээнд ажиллажээ.

2019 онд нийт зардлын 61.2%-ийг цалин хөлсөнд, 7.9%-ийг НДШ-д, 14.0%-ийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд, 12.1%-ийг хоолны зардалд, 0.6%-

ийг хангамж бараа материалын зардалд, 1.2%-ийг нормын хувцас зөөлөн эдлэлд, 3%-ийг бусад зардалд зарцуулжээ. Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр харуулбал:

| ДД | Зардлын төрөл  | 2018 он /мянган төгрөгөөр/ |           |                   | 2019 он /мянган төгрөгөөр/ |           |                   |
|----|--|----------------------------|-----------|-------------------|----------------------------|-----------|-------------------|
|    |  | Төл-гөө                    | Гүйцэтгэл | -Хэтрэлт, хэмнэлт | Төл-гөө                    | Гүйцэтгэл | -Хэтрэлт, хэмнэлт |
| 1  | Цалин хөлс   | 191859.6                   | 192704.4  | -844.8            | 230512.1                   | 229358.1  | 1154.0            |
| 2  | НДШ  | 23023.2                    | 23391.1   | -367.9            | 28813.9                    | 29761.5   | -947.6            |
| 3  | Гэрэл цахилгаан  | 2828.9                     | 2679.0    | 149.9             | 2992.3                     | 3251.9    | -259.6            |
| 4  | Түлш халаалт   | 36798.3                    | 36798.3   | -                 | 40302.9                    | 40302.9   | -                 |
| 5  | Ус   | 9074.2                     | 8974.1    | 100.1             | 9574.2                     | 8826.8    | 747.4             |
| 6  | Хоол   | 50524.8                    | 50345.5   | 179.3             | 45362.5                    | 45357.5   | 5.0               |
| 7  | Эм   | 70.3                       | 0         | 70.3              | 65.9                       | 0         | 65.9              |
| 8  | Бичиг хэрэг  | 136.2                      | 136.2     | -                 | 123.0                      | 750.0     | -627.0            |
| 9  | Тээвэр шатахуун  | 92.0                       | 92.0      | -                 | 61.7                       | 0         | 61.7              |
| 10 | Шуудан холбоо  | 109.8                      | 150.0     | -40.2             | 101.0                      | 100.0     | 1.0               |
| 11 | Ном хэвлэл   | 74.7                       | 0         | 74.7              | 70.3                       | -         | 70.3              |
| 12 | БҮТЭЗ  | 4390.6                     | 4345.0    | 45.6              | 224.0                      | 1442.0    | -1218.0           |
| 13 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | -                          | -         | -                 |                            |           |                   |
| 14 | Томилолт   | 136.2                      | 132.0     | 4.2               | 127.4                      | 0         | 127.4             |
| 15 | Зөөлөн эдлэл нормын хувцас                               | 667.7                      | 3253.1    | -2585.4           | 623.7                      | 4683.8    | -4060.1           |
| 16 | Хог хаягдал  | -                          | -         | -                 |                            | 60.0      | -60.0             |
| 17 | Урсгал засвар  | 1866.7                     | 474.0     | 1392.7            | 14673.5                    | 10550.0   | 4123.5            |
| 18 | Бусад зардал   | 800.7                      | 740.8     | 59.9              | 1229.9                     | 80.0      | 1149.9            |
| 19 | Аудитын хөлс   | 184.5                      | 200.0     | -15.5             | 171.3                      | 298.7     | -127.4            |
| 20 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага                             | 2046.9                     | 1482.6    | 564.3             |                            |           |                   |
| 21 | Нэг удаагийн тэтгэмж                                     |                            |           |                   |                            |           |                   |
| 22 | Хөдөө ОН-т ажилласны тэтгэмж                             | 26611.5                    | 26611.5   | -                 |                            |           |                   |
| 23 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж                     |                            |           |                   |                            | 206.4     | -206.4            |
|    | Дүн  | 351296.8                   | 352509.6  | -1212.8           | 375029.6                   | 375029.6  | 0                 |

2018 онд цалин хөлсний зардлыг 844.8 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 367.9 мянган төгрөгөөр, шуудан холбооны зардлыг 40.2 мянган төгрөгөөр, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлыг 2585.4 мянган төгрөгөөр, аудит

баталгаажуулалтын зардлыг 15.5 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлж, бусад зардлыг хэмнэн зарцуулж ажилласан байна.

2019 онд НДШ-ийн зардлыг 947.6 мянган төгрөгөөр, гэрэл цахилгааны зардлыг 259.6 мянган төгрөгөөр, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардлыг 1218.0 мянган төгрөгөөр, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлыг 4060.1 мянган төгрөгөөр, хог хаягдал зайлуулах зардлыг 60.0 мянган төгрөгөөр, аудит баталгаажуулалтын зардлыг 127.4 мянган төгрөгөөр, Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн зардлыг 206.4 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлж, бусад зардлыг хэмнэн зарцуулж ажилласан байна.

2018 онд 31808 хүүхэд өдөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 26877 хүүхэд өдөр хүмүүжиж, 4931 хүүхэд өдрөөр тасарсан буюу 84.5%-иар биелүүлжээ.

2019 онд 30100 хүүхэд өдөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 31379 хүүхэд өдөр хүмүүжиж, 1279 хүүхэд өдрөөр давсан буюу 104.2%-иар биелүүлжээ.

Тус байгууллага нь 2018 оны эхэнд 144.8 мянган төгрөгийн авлагатай байсан бол оны эцэст 111.5 мянган төгрөгийн /НДШ-ийн авлага/ авлагатай болж авлага 33.3 мянган төгрөгөөр буурсан, өглөг 37.7 мянган төгрөг байсан бол оны эцэст бүрэн барагдуулж өглөггүй болсон байна.

Үндсэн хөрөнгө 2018 онд 448330.1 мянган төгрөг байснаа 923279.2 мянган төгрөг болж 474619.1 мянган төгрөгөөр, бараа материал 21403.1 мянган төгрөг байснаа 27001.3 мянган төгрөг болж 5598.2 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хөдөлгөөний талаар:

2018 онд тоног төхөөрөмж 4280.0 /Жаргалант сумын Иргэдийн Төлөөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 213 дугаар тогтоолоор орлогод авсан/ мянган төгрөгөөр, газар 29520.0 мянган төгрөгөөр, дахин үнэлгээгээр 629944.8 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Тайлант онд дахин үнэлгээгээр барилга 188795.7 мянган төгрөгөөр хорогджээ.

2018 онд 12769.9 мянган төгрөгийн элэгдэл байгуулж, хуримтлагдсан элэгдэл 35967.8 мянган төгрөг болсон байна.

Тус байгууллага нь 2019 оны эхэнд 111.5 мянган төгрөгийн авлагатай байсан бол оны эцэст 9.8 мянган төгрөгийн /НДШ-ийн авлага/ авлагатай болж авлага 101.7 мянган төгрөгөөр буурсан, өглөггүй байсан бол оны эцэст 129.2 мянган төгрөгийн өглөгтэй болжээ.

Үндсэн хөрөнгө 2019 онд 923279.2 мянган төгрөг байснаа 935759.8 мянган төгрөг болж 12480.6 мянган төгрөгөөр өссөн, бараа материал 27001.3 мянган

төгрөг байснаа 20885.3 мянган төгрөг болж 6116.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн хөдөлгөөний талаар:

2019 онд тоног төхөөрөмж 9016.4 мянган төгрөгөөр, тавилга, эд хогшил 4900.0 мянган төгрөгөөр, программ хангамж 457.0 мянган төгрөгөөр /Жаргалант сумын Иргэдийн Төлөөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 19, 21 дүгээр тогтоолуудаар орлогод авсан/ тус тус өссөн байна.

Тайлант онд 1892.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг Жаргалант сумын Иргэдийн Төлөөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 293 дугаар тогтоолоор акталж, данснаас хасжээ.

2019 онд 29335.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулж, 1892.8 мянган төгрөгийн акталсан хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл хасч, хуримтлагдсан элэгдэл 63410.4 мянган төгрөг болсон байна.

#### Зургаа. Шалгуулагчийн ололттой талууд

○ Багш, туслах багш нарын дунд “Үлгэрч багш” хормогчин театраар үлгэрийг зөв ярьж дүрдээ хэрхэн хувирч байгааг илүү харуулахыг зорьсон тэмцээнийг амжилттай зохион байгуулж, хүн бүр ажлын байран дээрээ хөгжих алхам болжээ.

○ Давуу талаа ашиглан хүүхдийг бүх талаар хөгжүүлэх боломжтой дугуйлангийн хөтөлбөр боловсруулан, зөвлөгөө авч үзүүлэн арга хэрэглэгдэхүүнийг хийж сайжруулж ажиллаж байна.

○ Ховд аймгийн ЕБС, СӨБ-ийн хамт олныг нэгтгэсэн “Ховдын багш нарын нэгдсэн групп” ТББ-аас зохион байгуулсан ажилд ЗАН хамтран оролцож цэцэрлэгийн зорилтот бүлгийн хүүхдүүдийг хөгжүүлэх, баярлуулах зорилгорр 10 хүүхэд сонгож тэдний ахуй байдалтай танилцан, зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна.

#### Долоо. Өмнөх шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгасан талаар

Тус байгууллагын 2018 он санхүүгийн тайланд Төрийн аудитын газраас “Итгэл” үзүүлсэн байна.

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт өгчээ.

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн зардлын зүйл анги хооронд гүйлгэн зарцуулж, батлагдсан төсвийн хүрээнд зориулалтын дагуу ажилласнаар тайланд тусгасан боловч аудитын явцад 2894.4 мянган төгрөгийн хоолны хэмнэлтийг урсгал засвар, бусад зардлуудад зарцуулсан, үндсэн хөрөнгө худалдан авсан зардлыг бараа материал дансанд тайлагнасан, 1 хүнтэй

холбоотой 129.2 мянган төгрөгийг илүү суутгасан боловч буцааж өгөхөөр тайланд тусгаагүй зэрэг зөрчил илрүүлж, зөвлөмж өгсөн байна.

2016, 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт аудитын албанаас хийсэн шалгалтаар сахиулд хөдөө орон нутагт ажилласны нэмэгдэл олгосон, цалин хөлс илүү тооцон олгосон, эрхлэгчид мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгосон, багш нарт шалгуур үзүүлэлт хангаагүй байхад мэргэжлийн зэрэг олгож, нэмэгдэл хөлс олгосон, зарим ажилтнуудад цалин хөлсийг дутуу тооцон олгосон зэрэг зөрчлүүд илрүүлж, 2242.4 мянган төгрөгийн акт тогтоосныг бүрэн барагдуулж ажилласан байна.

#### Найм. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талаар

Шалгалтаар санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил дутагдлаас гадна дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тогооч нь батлагдсан хүүхдийн хоолны цэсэнд ороогүй 245800 төгрөгийн хүнсний материалыг хоолны талонд бичиж, нярав зарлагадсан нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтыг

2. Багш А-д 2018 оны 11 дүгээр сард 70867 төгрөгийн цалин хөлсийг дутуу тооцон олгосон нь Засгийн газрын 2018 оны 264 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтыг

3. 2019 оны 4, 5 дугаар сард Тогоочид 2 дугаар зэрэгтэй байхад мэргэжлийн зэргийн нэмэгдэлд 20%-иар тооцон олгосон нь Засгийн газрын 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтыг

4. 2018 онд Аргазүйчид үр дүнгийн урамшуулал олгохдоо эрхлэгчийн А/05 тушаалаас 34070 төгрөг илүү тооцон олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.7 дахь заалтыг

5. Цэцэрлэгийн эрхлэгчийн 2019 оны 08 сарын 26-ны өдрийн Б/09 тоот тушаалаар М-ийг багшаас туслах багш болгон шилжүүлсэн байхад 9 дүгээр сард багшийн цалингаар тооцон 229241 төгрөг илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралт, Цэцэрлэгийн эрхлэгчийн 2019 оны 08 сарын 26-ны өдрийн Б/09 тоот тушаалыг

6. 2019 оны 12 дугаар сард Жижүүр Т, Э нарт тушаал шийдвэргүйгээр 80464 төгрөгийн ур чадварын нэмэгдэл хөлс олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай

хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтуудыг, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 2 дахь заалтыг

7. Цэцэрлэгийн эрхлэгч нь ажилтнуудад улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгохоос гадна зарим тохилдолд амжилт гаргасан ажилтанд мөнгөн урамшуулал олгож байгаа нь 2017 оны Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийг, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолыг

8. Цэцэрлэгийн эрхлэгчийн зарим тушаалууд дугааргүй, үндэслэх хэсэгт буруу хууль эрх зүйн актанд үндэслэсэн, утга бичвэрийн алдаатай, архивын нэгж үүсгэхдээ А, Б тушаалыг ялгаагүй зэрэг зөрчлүүд илэрч байгаа нь Архивын ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тушаалаар баталсан Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, Архивын ерөнхий газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаалаар баталсан “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Энэ удаагийн шалгалтаар 710736 төгрөгийн зөрчил илэрч 639869 төгрөгийг орон нутгийн төсөвт оруулахаар, 70867 төгрөгийг ажилтанд нөхөн олгуулахаар Улсын ахлах байцаагчийн акт тогтоолоо.

#### Ес. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар

Шилэн дансны нэгдсэн системд 2018, 2019 оны байдлаар мэдээг бүрэн байршуулсан бөгөөд 11 төрлийн 13 мэдээг хугацаа хоцроож байршуулсан байна.

2020 оны 10 дугаар сарын байдлаар 19 төрлийн 110 мэдээллийг бүрэн, хугацаанд нь байршуулсан байна.

2018, 2019 оны 1, 2, 3, 4 дүгээр улиралд Шилэн дансны нэгдсэн системээр шилэн дансны тайлангаа илгээсэн байна.

#### Арав. Дүгнэлт

Тус байгууллага нь санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд гаргаж, зохих байгууллагаар баталгаажуулан, тушааж хэвшсэн байна.

Анхан шатны баримтын бүрдэл, нягтлан бодох бүртгэл хэвийн хэмжээнд явагдаж байгаа боловч батлагдсан хүүхдийн хоолны цэсэнд ороогүй хүнсний материал зарцуулсан байна.

#### Арван нэг. Цаашид авах арга хэмжээний санал

Жаргалант сумын 12 дугаар цэцэрлэгт:

1. Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах.

2. Мөнгөн урамшууллыг олгохдоо багш, ажилчдын ажил дүгнэж, Засгийн газрын 5 дугаар тогтоолыг баримталж олгох, бусад тохиолдолд урамшуулал олгохгүй байх.

3. Батлагдсан хүүхдийн хоолны цэсийн дагуу хоол үйлдвэрлэлийг явуулах.

4. Цалин хөлсийг хууль эрх зүйн хүрээнд тооцооллын алдаагүй тооцож, олгох.

5. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг хууль, эрхзүйн баримт бичигт нийцүүлэн шинэчилж мөрдөх.

6. Тушаал шийдвэрийг зөв төлөвлөж үндэслэлтэй гаргаж байх, байгууллагын архив албан хэрэг хөтлөлтийн стандарт, дүрэм журмуудыг мөрдөж ажиллах.

Шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллаж, зөрчлийг арилгах талаар тодорхой ажил зохион байгуулж, хийсэн ажлын тайлан, биелэлтийг албан бичгээр 2020 оны 12 дугаар сарын 25-ны дотор багтаан ирүүлэх.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБА